

## ДЭЛХИЙД ТАРХСАН МОНГОЛ ГАЗАР НУТГИЙН НЭРИЙН ТҮҮХ-СОЁЛЫН УЛБАА (Тойм өгүүлэл)

Э.Равдан

Монгол газар нутгийн нэр (МГНН) дэлхийн олон улс орны нутаг дэвсгэрт өдгөө хүртэл хадгалагдаж үлдсэн нь хүмүүн төрөлтний түүхэнд бидний монголчуудын түүх-соёлын үгээр бүтээсэн хөшөө дурсгал мөнөөс мөн. Түүхэн үүднээс нь үзвэл тэрхүү нэрсийг харь хүмүүс “импортолж аваагүй”, бидний ихэс дээдсийн маань ул мөр мөн болох нь маргашгүй үнэн болой. Тиймээс уг нэрсийг<sup>1</sup> том хэмжээгээр<sup>2</sup> Ази, Европын олон улс орныг хоёр ч удаа: эхнийх нь эртний хүннүчүүд м.о.т. 350-иад оны үед Европт нэвтэрсэн бол арай хожим, Баян хааны аваарчууд 552 онд Европыг дайлан цаад тал нь 568 онд Византийн нутаг дэвсгэрээс таслан авч Италийн хойд, баруун хэсэгтэй нэгтгэн Хазаарын их гүрнийг байгуулж явсан үе, удаахыг нь дундад эртний үеийн Чингис богдын их гүрэнтэй холбон үзвэл зохистой мэт санагдана. Эхний үеийг нэн эртний, сүүлчийнхийг нь дундад эртний гэж товчоор нэрлэн цааш өгүүлье.

Нэн эртний үеийн МГНН-ийн түүхэн улбаа түүхэн сурвалж бичгүүдэд төдийлөн тусаагүй, туссан бол нийтийн хүртээл өдгөө болоогүйтэй холбоотой эсвэл мартагдаж үгүй болсон, танигдахгүй болтлоо өөрчлөгдсөн ч байж болох талтай. Нөгөөтэйгүүр, баруун этгээдэд, тухайлбал, Европын улс орнуудад нэн эртний үед үлдэж хоцорсон нэр нь дундад эртний үеийн Монголын их гүрний үед үлдсэн олон нэртэй холилдон ялган зааглах аргагүй болсон байж болно. Энэ тухай бид хойно өгүүлье.

Гэхдээ нэн эртний үед Европ хийгээл Зүүн өмнөд Азийн улс орнуудад эртний монгол нэр үлдсэн байж болох баримт хангалттай байна гэж үзэж болно. Түүний заримаас нь дурдвал эртний хүннү, аваарчуудын нутаглаж байсан өнөөгийн Умард Хятадын Жоу Жань (Жужань), Аваар хоёр нь түүхч Г.Сүхбаатарын нотолгоогоор угтаа нэг нэр бөгөөд утга нь “нуруу” бөгөөд тэдгээр нь Алтайн өвөг хэлтэн<sup>3</sup> байжээ. Эртний хүннү, аваарчуудыг түрэг-

<sup>1</sup> МУИС-ийн “Нэр судлалын төв”-өөс эрхлэн сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд гаргасан “Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр” (УБ., 2005, 2006, 2013) гурван дэвтэр товхимолд гадаад, дотоодын судлаачдын энэ талын цөөнгүй бүтээлийг эмхэтгэн гаргаж нийтийн хүртээл болгосон болно. Мөн эртний монголчуудын газрын зураг, дэлхийн улс орнуудад тархсан МГНН-ийн тоймыг миний бие нэг биш удаа өмнө нь хэвлүүлсний заримаас нь дурдвал: Э.Равдан. Эртний болон дундад эртний Монгол гүрний нутаг дэвсгэр, газарзүйн биетүүдийн нэр дэлхийн болон бүс нутгийн газрын зурагт туссан тоймоос-*Монгол орны газрын зураг болон газар нутгийн нэрийн судалгааны асуудлууд*, Эмхэтгэж хэвлүүлсэн Х.Фүтаки, А.Камимүра, Э.Равдан, Л.Чулуунбаатар (УБ., 2012, 49-62), Э.Равдан. Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэрийн тойм- *Монголын нууц товчоон ба дундад зууны Монголын түүхийн судалгаа* (МУ. ШУА, Түүхийн хүрээлэн) Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл (УБ., 2010, 279-286) зэрэг болно.

<sup>2</sup> Тийм учраас бид өнөөгийн Монгол улсын хилийн гадна байгаа монголчуудынхаа нутаг орны газрын нэрийг энд хамруулаагүй болно.

<sup>3</sup> Сүхбаатар Г. Монгол Нирун улс, УБ., 1992-ээс үзнэ үү

**Э.Равдан**

ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн  
ravdan2000@yahoo.com

**С.Чулуун, Э.Равдан, Х.Фүтаки, А.Камимүра**

*Монголын газрын зураг, газрын нэр судлал*

*“Адмон принт” ХХК хэвлэлийн газар. Улаанбаатар, 2015, ISBN 978-99973-0-702-6*

монгол хэлтэн байсныг János Harmata, Gönül Yılmaz нарын бүтээлд<sup>4</sup> өнөөгийн Мажаар улсын нутаг дахь Жаношидын 228-р булшнаас гарсан зүүний хавтаганы дөрвөн талын бичээсийг тайлж уншсан дөрвөн өгүүлбэрт эдүгээгийн түрэг хэлэнд байгаа үгээс гадна “эгч” гэсэн монгол үг байгаа нь анхаарал татахаар байна. Түүнчлэн Гиблиа Немет 1930-аад оны үед эртний аваар, хүннүчүүдийн бичгийн сурвалжаас үүдэн:<sup>5</sup>) цол хэргэм заасан нэр: *qayan, qatun, tarqan, tudun, ууурувь*, хүний нэр: *Bayan, Qamsavči, Kōk, Solaq* зэрэг баримтыг дурджээ.

Европын улс орнуудад байж болох нэн эртний монгол газрын нэрийн баримтууд нь дундад эртний үеийн баримтуудтай холилдон зааглах аргагүй болсон байж болох таамаглалыг бид дэвшүүлж байгаа юм. Хүннү хийгээд аваарчууд нь 626 онд Константинополь руу довтолж яваад анхны том ялагдал хүлээжээ. Түүнээс хожуухан тэд дотоодын зөрчил, гадны шахалтаар слав олон овог аймгийнхан Балканыг орхихын хамт баруун этгээд дэх эрх мэдлээ бага багаар алдсаар Газрын дундад тэнгис, Каспийн тэнгисийн эхэнд Хазаар гүрэнд нэгдэж, хожим Х зууны үеэс одоогийн Унгар буюу Мажаарын нутаг, Бессераб, Кавказын нуруу, Ижил мөрний ай сав зэрэг газраар таран нутагшжээ. Тиймээс дээрх бүс нутагт тархсан МГНН нь дундад эртний үеэс өмнөх үед хамаатай байхыг үгүйсгэх аргагүй. Мөн энэхүү учир шалтгааны үүднээс өнөөгийн мажаар хэл аялгуунд байгаа монгол язгуур бүхий олон нэрийг бүхэлд нь дундад эртний үетэй холбоотой гэх учиргүй бөгөөд тэдгээрийн заримыг нь түүнээс өмнө Алтайн уугуул хэлтнүүд мажааруудыг Европын төв хэсэгт нүүдэлж очихоос өмнө суурьшиж байсантай холбон үзүүштэй. Түүнчлэн өнөөгийн Афганистаны хазааруудын гарал үүсэл Пеллиогийн нотолсноор Чингис богдын цэргийн нэг хэсэг байсан гэдэг ч эргэлзээ төрүүлэхээр байна. Тэр нь эртний Хазаар гүрний нэртэй холбоотой байхыг үгүйсгэж болохгүй. Гэхдээ энд давхар нотолгоо шаардлагатай болно.

Хэрэв Европт тархсан эртний МГНН м.о.т. 4-6 зууны үеийн хүннү, аваарын гүрэнтэй холбоотой бол өнөөгийн Хятадын нутаг дэвсгэрт байгаа монгол язгуур бүхий олон нэрийг бүхэлд нь мөн Хөх гүрний<sup>6</sup> үетэй холбон үзэж болохгүй. Түүний нэгэн нотолгоог БНХАУ-ын өнөөгийн нутаг дахь эртний монгол газрын хэд хэдэн нэрийг АНУ-ын эрдэмтэн П. Бүүдберг 976-983 оны үед бүтээсэн эртний Сүн гүрний “Хязгаарт ертөнцийн орон зайд болсон эрин үеийн их үйлийн товъёг” алдарт толь бичигт туссан газрын хятад биш олон оноосон нэрийн заримыг түрэг-монгол үгтэй галигаар нь дүйцүүлж: 庫利 K’uli голыг “барлаг эсвэл зарц” гол, 磨勒 Mo-le хотын нэрийг “балиг” загасны нэр, 骨胡 Ku-hu голын нэрийг “хуурай”, 庫磧 K’uto голын нэр “худ ураг” гэсэн язгуураас үүдэлтэй болохыг тогтоожээ<sup>7</sup>. Энэ тухай дээрхийн ижил цөөнгүй жишээ татан өгүүлж болно. Тэдгээрийн нэг нь нэн эртний Монголын түүхтэй холбон 1179 онд зохиогдсон Ци-дань-го-цзи түүхэнд

<sup>4</sup> János Harmata, Gönül Yılmaz. De La Question Concernant La Langue Des Avars, *Inscriptions Runiques Turques En Europe Orientale* (Ankara, 1988)

<sup>5</sup> Voig Gyula Németh, *A honfoglalás magyarországi kialakulása*. Budapest 1930, pp. 103, sqq.

<sup>6</sup> Юань гүрний монгол нэрийн тухай судлаачдын санал нэлээн зөрүүтэй байна. Энэ тухай А. Пунцаг (Тэнгэрийн их Юань улсын түүхэн тэмдэглэл, УБ., 2010, 15-25 т.)-аас дэлгэрэнгүй үзнэ үү. Тэрхүү хувилбаруудыг нэг болгон манай нэрт солонгосч эрдэмтэн Б.Сумьяабаатар 2008 онд “Юань” нэрийг монголоор “ХӨХ” болохыг эртний цөөнгүй толь бичгээр мөшгөн нотолсон байна. Тэрбээр: “<...> монголчуудын ихэд эрхэмлэдэг, “Хөх тэнгэр”, “Хөх монгол” гэдэгт ордог “Хөх” гэсэн утга 元 (нан. уибн)-д байна. Энэ нь ойр зуурын, бага, дунд гарын толь үгүй. Хятад хэлний үгийн далай (辭海) хэмээх их толь (7-р утгыг үз.), “Хятад хэлний Их толь” (Тайванд хэвлэсэн, 21-р утгыг үз.), “Япон Хас толь” (21-р утгыг үз.) -нуудад байна. 元 (уибн) нь 玄 (хөх, тэнгэр өнгө)-тэй ижил утгатай (辭海) гээд, Юаны үед тийн хэрэглэж байсан гэсэн тайлбартайгаа байна. (...)” гэжээ: (Acta Mongolica, 2008 (306), 28-р т.) Бид эл хувилбараар бүтээлүүддээ их гүрнээ “Хөх” хэмээн нэрлээд байгаа юм. Тэгэхийн өөр нэг ерийн логик учир нь уг нэрийн талаар манай судлаачдаас санал болгосныг А.Пунцагийн тоймлосон монгол хувилбаруудад бараг бүгдэд нь ХӨХ давтагдаж байгаа нь нэгийг хэлээд байгаа юм биш үү. Нөгөөтээгүүр, бид их гүрнээ хэзээ болтол харь нэрээр нь нэрлэж байх вэ дээ. Нэгийг бодох цаг аль хэдийн болсон мэт санагдана.

<sup>7</sup> Boodberg Peter Alexis, "An Early Mongolian Toponym", *Harvard Journal of Asiatic Studies* 19 (Dec. 1956), 407-408

орсон Кидан гүрний зургийг тэмдэглэж болох юм. Эл зурагт эдүгээ гаргагдаж байгаа цөөн нэрийг бид д-р М.Чимэдцэеэгийн орчуулгаар доор жагсаав. Үүнд: 佛 Бурхан уул, 北海 Хойд далай, 上京 Дээд нийслэл, 新上京 Шинэ Дээд нийслэл, 长白山 Урт Цагаан уул (Одоогийн Солонгост бий), 王府 Хааны ордон, 北海 Вейхай, 北平 Хойд тэгш, 北岳 Хойд толгод, 南京 Нанжин (Өмнөд нийслэл) болно. Бусад нэрийг зургаас унших боломжгүй байв. “Кидан” нэрийн түүхэн гаргалгааг П.Пеллио-гийн “Catai”<sup>8</sup> өгүүллээс үзэж болно. Тэрбээр уг нэр өнөөдрийн бидний “хятад”-нэрийн язгуур болохыг хөдөлбөргүй нотолжээ. Түүнээс улбаалан өрнийн зарим хэлэнд, тухайлбал орос хэлэнд “китай” нэр Дундад Азийн хэл аялгуугаар дамжин оржээ.

Дэлхийд тархсан нэн эртний монгол газрын нэрийн бүрэлдүүнд өнөөгийн бидний үеийн судлаачдын санал болгосон япон, солонгос хэлэнд орсон монгол зарим нэрийг хамруулан үзэхэд буруугүй мэт санагдана. Тийнхүү үзэхийн гол үндэслэл нь монгол, япон, солонгос хэлийг Алтайн өвөг хэлний бүлэгт багтаан үзэх үзлийг олонх судлаач өдгөө хүлээн зөвшөөрөх болсонтой шууд холбоотой бөлгөө. Түүний нэгэн тод жишээ нь монгол хэлний эртний *etügen* нэрийн язгуурыг “дархан, богд, хэмжээ дамжаа нэн их” гэсэн ерөнхий утга бүхий япон хэлний мөн эртний язгуур *ita, itu, ito, iti* зэрэгцүүлэн үзэж проф. М.Хашимото<sup>9</sup> уг язгуураас үүдэн дараах япон нэрийг монгол гаралтай хэмээн нотолсон нь болно. Үүнд: Окинава арал: *juta* - (эм бөө), Хоккайдү арал: *tak* (Ачну) “үг, хэл”, Гол арал (Аомори муж): *tako (itiko)* \*эм бөө\* болно. Тэгвэл манай проф. Б.Сумъяабаатар хэдэн жилийн өмнө солонгос хэлэнд цөөнгүй монгол нэр байдаг тухай *Шар гол* нэрээр жишээ болгож байв. Түүнчлэн солонгос хэл, тэр дундаа Чезу арлын хэл аялгуунд орсон монгол үгсийг сүүлийн жилүүдэд тууштай судалж байгаа д-р Ким Ки Сонь<sup>10</sup>-ийн бүтээлээс үзэж болно. Тэрбээр Ph.D-ын зэрэг горилсон нэгсэдэвт зохиолынхоо хураангуйд нийт 225 солонгос үгийг монгол язгууртай гэж үзжээ. Тэдгээрийн дотор олон тоогоор бүртгэгдсэн зарим зүйл нэрээс нь дурдвал: газар усны нэр 39, хүний холбогдолтой нэр 22, ашигт малтмалын нэр 18, хүний бие махбодын нэр 17, ан амьтны нэр 15, байгалийн зүйл нэр 14, эд зүйлсийн нэр 11 гэх мэт болно. Зохиогч<sup>11</sup> Олон улсын монголч эрдэмтдийн VII их хуралд тавьсан илтгэлдээ дараах газар усны дэвсгэр нэрийн зэрэгцэлийг санал болгожээ. Үүнд: *сол. урам (uram)* - монг. *орой, сол. сара бун (sara bu)* монг. *ян сарьдаг, сол. нүр мүд (nürü müd)* -монг. *нуур, сол. мүс-нэ (müs-ne)*-монг. *мөс, сол.хөл (kil)*-монг. *гол, дүрэц-мүл (dure-mül)*-монг. *тойром, сол. гүэ (yue)* -монг. *агуй* болно. Ким Ки Сонь дээрх баримтыг 1273 оноос Монголын их гүрэн Япон, Өмнөд Сүн улсыг эзэлж авахын тул Чезу арлыг цэргийнхээ түшиц газар болгож байсан үйл явдалтай холбон тайлбарлажээ. Чезу арлын хэл аялгуунд байгаа монгол үгийн талаар өөр судлаачдын өөр нэгэн хувилбараар Хубилайн их цэргийн хэсэг Зүүн өмнөд Азийн улс орныг эзлэх аян дайныхаа явцад далайн шуурганд цохигдон Чезу аралд суурьшсан гэж үзсэн нь ч бас бий. Гэхдээ бидний үзлээр дээрх олон нэрийн зарим нь Алтайн өвөг хэлний нийтлэг язгуурууд дээрх үйл явдлаас өмнө ч солонгос хэлэнд байсан байхыг үгүйсгэх аргагүй бөлгөө.

Япон, солонгос нэн эртний нэрсийн хувьд олон тохиолдолд зөвхөн хэлний үүднээс, тодруулбал үгийн эртний язгууртай холбон тайлбарласан тул уг баримтуудыг түүхэн үүднээс нь сурвалж бичгүүд, тэр дундаа дээрх улсуудын эртний хийгээд дундад эртний газрын зургуудаар сайтар шүүн нягтлах шаардлагатай мэт санагдана.

Одоо дэлхийн улс орнуудад дундад эртний үед тархсан МГНН-ийн зүйлийг доор авч үзье. Энэ тухай судалсан цөөнгүй улс орны судлаачдын бүтээлийг өмнө бидний тэмдэглэсэн “Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр” гурван дэвтэр товхимолдоо олонхыг нь

<sup>8</sup> Pelliot P. Notes on Marco Polo, Paris, 1959, pt 1, 536. Уг өгүүлэл монгол хөрвүүлгээр бидний эрхлэн бэлдсэн “Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр” (УБ., 2006, 83-110.) товхимолд бий.

<sup>9</sup> Хашимото М. “Монголын нууц товчоон”-ны “*etügen, ötögen*” гэдэг үгийн тухай *Mongolica* vol.20 (41), 2007, 209-11

<sup>10</sup> Ким Ки Сонь. Солонгосын Чезу арлынхны хэлэнд орсон монгол гаралтай үгс ба Юань улс, Гуулин улсын түүхийн холбогдол” (УБ., 1993)

<sup>11</sup> Ким Ки Сонь. Чезу арлынхны хэлэнд орсон монгол гаралтай болон нэг гаралтай газар усны нэр “*Mongolica*” In *Interregional Annual of Mongol Studies*, vol.11 (32)8 2001, 66-72

монголчлон, цөөнхийг нь уг эхээр нь хэвлэн нийтэлсэн болно. Тэдгээрийг зохиогчдоор нь тоймлон дурдъя. Үүнд: Тэргүүн дэвтэрт (УБ., 2005): А.Wylae (1878), Б.Я.Владимирцов (1911, 1929, 1929), В.А.Казакевич (1934), V.Minorsky (1956), J.Kler (1956), W.Heissig (1966), Э.М.Мурзаев (1973), В.Ф.Барашков (1973), Г.К.Конкашпаев (1956), К.Конкобаев (1980) болно; Дэд дэвтэрт: P.Woodberg (1956), N.Poppe (1956), P.Pelliot (1959, 10 өгүүлэл), Отгон (1991), Бүрэнбат (1990), Түмэн-Өлзий (1990), Ш. Сундуй (2002), Чандмань (1986), Хурц (1999), Алтан-Оргил, Наранцогт, Алтанзаяа (1999), У.Хүрэлбаатар (1993), Алтаншаа (1993), А.Лутжаргал (2000), Н.Батжаргал (1988), Соёл (2005), Самгаа (1997), Алтан-Оргил (2005) болно. Эл дэвтрийг бид Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойд зориулсан тул эзэн богд Чингисийнхээ нэр үйлтэй холбоотой БНХАУ-ын ӨМӨЗО-ны газар нутгийн нэрийн 120 домог, “Монголын нууц товчоон”-д тэмдэглэгдсэн газар усны нэрийн судалгааны хүрээнд хийсэн ӨМӨЗО-ны судлаачдын цөөнгүй өгүүллийг багтаасан болно; Гутгаар дэвтэрт: Э.Равдан (2013), Ц.Шагдарсүрэн (2013), Я.Цэвэл (1946), G.Jarring (1961), O.Molchanova (1996/1998), O.Молчанова (1973), Н.Jankowski (2005), Г.Ф.Саттаров (1984), И.Н.Голубева (1992), В.Э.Очир-Гаряев (1988), В.Н.Хонинов (2005), Т.А.Гуриев (1974), К.Б.Самтокова (2008), Н.М.Иванова (1997), А.Матышяк, И.Рошчипала, У.Борэцки (2003), М.Н.Мельхеев (1969) болно. Дээрх бүтээлүүдэд МГНН өнөөгийн Иран, Польш, Гүрж, Казахстан, Узбекистан, Киргиз, ОХУ-ын бүрэлдүүнд эдүгээ багтаж байгаа Крым, Осетин, Татаар, Саха-Якут, Ижил мөрний ай сав нутаг, Алтайн хязгаар, Халимаг, Буриад, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгуурын ӨЗО зэрэг улс орнуудын нутаг дэвсгэрт өдгөө хадгалагдаж ирсэн монгол язгуур бүхий нэрийн судалгааны өгүүлэл, диссертацийн хураангуй, илтгэл зэргийг олонхыг нь бүрэн эхээр, заримыг нь хэсэгчлэн эмхэтгэн хэвлэж уншигч олны хүртээл болгов. Дээрх бүтээлүүдэд тухай тухайн улс орнуудад тархсан наад зах нь ойролцоогоор 3000 орчим монгол нэрийн судалгаа багтжээ. Нэр бүрийн ард бидний монголчуудын түүх-соёлын мөр бий гэж бодвол Монгол улсын түүхэнд чухал баримт болох төдийгүй бидний түүх-соёлын үгээр бүтээсэн хөшөө дурсгал гэж нэр бүрийг үзүүштэй. Тиймээс: “Танай юм шүү” хэмээн тогтоож өгсөн орон орны дээрх судлаачдад бид бөхийн ёсолж тал өгөх ёстой бөлгөө.

Гэхдээ дээрх олон нэрийг судлаачид юуны өмнө хэлний үүднээс нь, тухайлбал үгийн эртний язгуураар нь хөөн тогтоосон нь дийлэнх хэсгийг нь эзэлж байгаа бол, түүх-соёлын үүднээс нь хандсан нь цөөнх нь гэхээр ажээ. Гэхдээ өмнөх хоёр талыг хоёуланг нь хослуулан авч үзсэн ч бас байна. Тиймээс бид дэлхийн улс орнуудад тархсан МГНН-ийн түүх-соёлын талыг энэ удаа илүүтэй анхаарч байгаа тул тэр талаас нь дээрх олон бүтээлээс сорчлон түүвэрлэж жишээ болгох төдийгөөр хойно өгүүлсү. Түүний тул бид Европын улс орнуудаас өнөөгийн Польш, Дундад Азиас Иран, ОХУ-аас Ижил мөрний ай сав газар, Кавказ хавийн улс орны нутагт байгаа МГНН-ийн судалгааг сонгон авав.

“Алс тэртээх Монголоос Монколицэ хүртэл” (Түүх, уламжлал) гэсэн өгүүллийг Firma Bracia Urbanek пүүсийн ивээн тэтгэлэгээр 2003 онд Лович – Монколицэ-д польш, монгол хэлээр хэвлэснийг нь бид дээр заасан товхимлын Гутгаар дэвтэрт монгол эхээр нь цөөн үг, хэллэгийг нь залруулан хэвлэсэн болно. Эл өгүүллийг католиг санваартан Адам Матышяк боловсруулан бүтээснийг Польшийн монгол судлаач Ирэнэуш Рошчипала монголчилсон байна.


Энэхүү томоохон өгүүлэлд 1227 онд эзэн Чингис богд тэнгэрт хальсны дараа Батын цэргүүд өнөөгийн Украин, Морави буюу өнөөгийн Чех, Унгар, Польшийг хэрхэн эзэлж өөрийн мэдэлд оруулсныг түүхэн сурвалж бичгүүдээс эшлэн газрын зургаар харуулжээ. Түүнчлэн уг өгүүлэлд Монголын их цэргийн хэсгүүд Польшийн Сандомерь, Краков, Вроцлав, Легниц зэрэг хотыг хэрхэн дайлсан тухай түүхэн баримтаар он, сар, өдрөөр нь тогтоон өгүүлсэн нь нэн сонирхолтой. 1241 онд монголчууд өнөөгийн “Монколицэ” тосгон байгаа Польшийн нутгийг өөрийн мэдэлд оруулсан байна. Монколицэ нь Лодзь, Лэнчыца, Лович гэсэн гурван хотын дунд Польшийн төв хэсэгт байрладаг. Монколицын байрлалын талаарх нарийвчилсан зураглал 1885 оны «Польшийн Вант Улс болон славын

бусад орнуудын газарзүйн толь бичиг» номонд байдаг ажээ. Уг номноос Монколицэгийн байрлалын тухайд: *Монколица тосгон болон Вола Монкольска тосгон нь Лович хошууны Лубянкүв багт Гловнагаас баруунтаа 7 мод газар, харин Ловичоос 33 бээрийн цаана оршдог хэмээснийг үзэж болно.* (*Słownik Geograficzny Królestwa Polskiego i innych krajów słowiańskich*, red. F. Sulimierskiego, B. Chlebowskiego, W. Walewskiego, Warszawa 1885, s. 217) Эл баримтаас үзвэл Монголицэгаас гадна бас Вола Монкольска гэдэг бас нэгэн тосгон байгаа ажээ.

Адам Матышяк бүтээлдээ өгүүлэхдээ: “1237 онд Монгол руу шашин номлох аянд мордоод тэндээс Киев, Унгараар дамжин ирсэн франц гаралтай эр Ян ди Пиано Карпини монголчуудын гадна төрхийн тухай дүрслэн бичихдээ: «Монгол орны оршин суугчдын гадна төрх өөр бусад бүх хүмүүсийнхээс ялгаатай. Тэдний нүд, хацар хоорондын зай нь бусдынхаас өргөвтөр. Хацар нь мөн эрүүнээсээ харьцангуй хол зайтай байрлагдсан. Шулуун, томгүй хамартай, жижигхэн онигордуу нүдтэй, зовхи нь хөмсөг хүртлээ өргөөстэй. Ерөнхийдөө ганц нэг хүнээс бусад нь бүсэлхий нарийн, бараг бүгдээрээ дунд зэргийн нуруутай. Бараг бүгдийнх нь эрүү хавиар сахал тун шингэн ургадаг, зарим нэг нь дээд уруулын дээгүүр живэр сахал тавих бөгөөд эрүү хавиарх багахан сахал үсээ хусалгүй оршидог. Толгой дээрээ лам нарынхтай төстэй гэзэг ургуулж, эрчүүд бараг бүгдээрээ нэг чихнээс нөгөөг хүртэл гурван хуруу газар үсээ хусдаг. Магнайн тус газраар мөн л бүгд үсээ хоёр хуруу орчим газарт хусах ба харин магнайн хоёр талаарх үсийг голынхоос нь ялимгүй урт ургуулан бусад хэсэгтээ гэзэг тавьж хоёр салаа сүлжин чихнийхээ ард боодог. Хөлийн ул нь харин жижигхэн болой» гэснийг эш үндэс болгон аваад Монколицэгийн оршин суугчдын өнөөгийн гадна төрхийг зуун хувь батлан хэлэхэд хэцүү хэдий ч зарим нэг ижил төстэй шинж чанарыг ялангуяа ахмад настнуудын дунд ажиглаж болно. Монколицэгийн унаган оршин суугчдын дунд өөрсдийн монгол түүхэн гарал үүсэл, үндэс угсаагаа үе удамдаа дамжуулж үлдээдэг заншил тогтжээ” гэжээ. Өөрөөр хэлбэл, зохиогч уг тосгоны уугуул иргэд өөрсдийн өвөг дээдсээ Батын их цэргээс үлдэж хоцорсон хүмүүс хэмээн үздэг байна.

Өнөөгийн Ираны Өрөмийн<sup>12</sup> нуур орчмын МГНН-ийг В.Ф.Минорский<sup>13</sup>: “Монголчуудын төрөлх нутаг нь Урмия голын зүүн хэсгээс 3,000 гаруй бээрийн зайд оршдог бөгөөд тэдний

<sup>12</sup> Өрөм нуур нь 37°42'N 45°19'E / 37.7°N 45.317°E оршдог, Төрөл: Давст, Урт: 140 км, Өргөн: 55 км, Гадаргын талбай: 5200 км. кв. Хамгийн гүн газар нь: 16 м. болой.



“Өрөм” нь манай давс, хужиртай нуурийн өрөм мөн шиг байна. Давс, хужир, шүүтэй нуурын ус нь намрын цагт өтгөрч доош сууж өнгөн дээр нь цайран харагдах цагаан тундасыг монголчууд “өрөм” хэмээмэй. Эл нэрийн гарлыг Минорский хөндөлгүй орхижээ.

<sup>13</sup> МИНОРСКИЙ Владимир Фёдорович (Minorsky V.) (1877-1966). Орос үндэстэн. Ойр дорнодын хэл, түүх, соёл судлаач. Москвагийн их сургуулийг 1900 онд дүүргээд Лазеревын Ойр дорнодын хэлний дээд сургуульд 3 жил суралцаж дараа нь дипломат албаны хэргээр 1902 онд Иранд анх очсон байна. Лондон, Кембриж, Брюсселийн их сургуульд перс, түрэг зэрэг хэл аялгуу, Ойр дорнодын түүх, соёлын тухай лекц уншиж тэрхүү их сургуулийн профессороор 1923 оноос эхлэн ажиллаж байжээ. Монгол газар нутгийн нэртэй холбоотой дараах бүтээлийг тэрбээр туурвисан байна. Үүнд: “Mongol Place-names in Mukri Kurdistan” (*Mongolica* 4) – *Bulletin of the School of Oriental and African Studies University of London*, vol. 19, 1957, pt.1), “The Kela-Shin and the earliest monuments in the basin of Lake Urmia” ( in Russian) – *Записки Восточного отделения*., т.24, 1917, 145-184, Sawd-j-bulak in E.I., and Poman and Byzantine campaigns in Atropatene – *BSOAS*, xi, 2, 1944, 243-265.

дарангуйлал эл нутагт урт удаан байж чадалгүй зургаан зууны өмнө төгсгөл болсон гэдгийг сонссон хэн ч болов гайхана” (Minorski (1957: 65 Орч. Э.Р.)<sup>14</sup> гэжээ. Зохиогч Өрөмийн нуур орчимд XIII-д ирж Марагхад хотоо байгуулж ил-хаадууд Жагхатугийн дулаан хөндийд өвөлжиж байсан гэж Rashid al-din, ed. Quatremere, under 660/ 1263; ed. Jaha (Prag), 44 зэргээс эш татан өгүүлсэн байна. Энд дахиад “Марагхад” гэсэн нэг хотын нэр гарч ирлээ. Энэ тухай бидэнд аль нэгэн мэдээлэл байгаа болов уу?! Минорский Ажербайжан, Гүрж, болон Ойр Дорнодын бусад улсын түүхэн сурвалж бичиг, “МНТ”, 1928 онд Н. Поппегийн хянан боловсруулсан “Mongol-Turkish Muqaddimat al-adab” (Moskow 1928) зэргийг ашиглан Өрөмийн нуур хавьцааны 50 гаруй монгол газрын нэрийн түүхэн гарлыг тогтоожээ. Үүнд: 1) гол ус: *Hūlān-mūrān* (Улаан мөрөн), *Jaghātū* (Захт эсвэл Цагаант), *Talvāntū* (тавиун), *Sāvuj-bulag* г.м. 2) уул, толгод: *Qarj-daban*, *Chaghān-daban* (Цагаан даваа) г.м. 3) тосгон, дүүргүүд: *Akhtāchi* (аггач), *Burhan* (бурхан), *Qutlu-Burhānlu* (qutlu-адис хүртсэн, ариун дагшин), *Makuatū* (Meketū – мэхт), *Qaralar* (түрэг үг хэдий ч khara/qara utg монголоор ‘хар ажлын (гар) утгатай дүйнэ.), *Chelik* (cherlik–цэрэг), *Sā'in-qala* (одоо түүнийг Shāhin-dez гэдэг болсон (сайн), *Sā'in-gedūk* (перес үг gedūk-хоолой, хөндий), *Aghaj-dri* (Hoyin-irgen -ойн иргэн), *Havaki* (habaki-аалз), *Tokhta* (тогтох), *Shilān-ābād* (шөл), *Hobātū* (овоот), *Nāchid* (шонхор), *Chūkatū* (чулуутай) г.м. 4) овог аймаг: *Qatanqur* (хатингар), *Oryad* (ойрод), *Chār-oumaq* (Чаар аймаг), *Toulachi* (туулайч, туулай баригч) гэх мэт болно.

ОХУ-ын Ижил мөрний ай сав газрын монгол нэрийн асуудлыг Э.М.Мурзаев, В.Ф.Барашков, Р.Х.Субаев, В.А.Никонов зэрэг судлаач аль нэгэн байдлаар судалжээ. Тэдгээрээс бид В.Ф.Барашков<sup>15</sup>-ын “Монголизмы в Топонимии Среднего Поволжья”<sup>16</sup> бүтээлийг гол болгон доор өгүүлье.

В.Ф.Барашков Ижил мөрний ай сав газар дахь монгол язгуур бүхий нэрийн асуудлыг “МТӨ” I мянганы эцэс, II мянганы эхэн үед хамаарах түүхэн үйл явдлаас улбаатай. Чухамхүү энэ үед Дундад Ижилийн сав нутагт Баруун өмнөд Шивэр болон Монголоос нүүдэлчид ирж эл нутгийг идэвхитэй үйл ажиллагааныхаа талбар болгож байжээ (Барашков 1973: 250) гэж тэмдэглэсэн байна. (Харамсалтай нь тийнхүү өгүүлснийхээ түүхэн эх сурвалжийг заасангүй.) Харин хожмын дундад эртний тэр бүс нутгийн үйл явдлын тухай тэр бээр В.В.Бартольд (Сочинения, т.5: 136, т.3: 710), Б.Д.Греков, А.Ю.Якубовский (Золотая орда и ее падение М., 1950: 65), В.В.Карголов (Монгол-татарское нашествие на Русь М., 1966: 29) А.Н.Насонов (Монголы и Русь М.-Л., 1940:54), П.Рычков (Топография Оренбургская. СПб., 1762) П.С.Палас (Путешествие по провинциям Российской империи. СПб., 1809: 175) эш үндэс болгон өгүүлсэн байна. Тэр дундаа В.В.Бартольдын өмнө заасан бүтээлээс эшлэн Барашков: “XIII зууны эхэн үед монголчууд энд дайлаар ирж Ижилийн булгаарыг бут цохин өөрийн болгожээ. Бат хаан олон цэргийнхээ хамт 1236-1237 онд Ижилийн Булгаарт өвөлжсөн байна. Тэндээс Самаарын Лука хавиар Ижил мөрнийг гэтлэн Сызрань-Пензийн чиглэлд хөдлөн эртний Оросын вант улсуудын эсрэг аян дайнаа эхэлжээ. Хожим нь Дундад Ижилийн сав газар нэлээд удаан хугацаагаар нутгийн нь нэг гол хэсэг болон Алтан ордын улсын мэдэлд байв.” гэжээ. Өмнөх санаагаа Барашков Бартольдын: “Монголчууд эзэлж авсан Ижилийн булгааруудын нутагт суурьшжээ. Булгаар хотыг

<sup>14</sup> “Mongol Place-names in Mukri Kurdistan” (Mongolica 4) – Bulletin of the School of Oriental and African Studies University of London, vol. 19, 1957, pt.1) өгүүллийн монгол орчуулга бидний “Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр”-ийн Тэргүүн дэвтэрт (УБ., 56-73) бий.

<sup>15</sup> БАРАШКОВ Венедикт Федорович (1926-1997) Ульяновскийн Багшийн дээд сургуулийн профессор. Тэрбээр орос хэлний оноосон нэр судлал, нутгийн аялгуугаар 70 гаруй эрдэм шинжилгээний бүтээл туурвижээ. Тэдгээрээс нэрзүйтэй холбоотой зарим бүтээл нь: *Топонимия Ульяновской области, По следам географических названий Ульяновской области, А как у вас говорят?, Ульяновское Поволжье: языки, говоры, ономастика», «Русские говоры Ульяновской области»* зэрэг болно.

<sup>16</sup> Эл өгүүлэл анх “Ономастика Поволжья” (Материалы III конференции по ономастике Среднего Поволжья), в.3, Уфа, 1973, 250-254 хэвлэгджээ. Бид эл эхийн монгол хөрвүүлэгийг “Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр”-ийн Тэргүүн дэвтэрт (УБ., 2005:101-105) оруулсан болно.

сэргээн босгож Зүчийн мэдэлд байсан газар нутгаас зөвхөн энд нэгээхэн үедээ зоос цутгадаг байжээ. (136)” “Монголчуудын үед Ижил мөрний ай савд өөр хотууд<sup>17</sup> ч үүсч буй болсон” (710) гэсэнтэй холбон тэмдэглэсэн нь бидний анхаарлыг зүй ёсоор татах учиртай. Түүхэн эл үйлээс үүдэн Барашков ус бидний нэр томъёогоор дэвсгэр нэрээр: 1) Сызраны хойгуур даялсан Ижил мөрний баруун салаа; 2) Ульянов мужийн Суур дүүргийн Суур голын баруун салааг нэрлэдэг болохыг нотолжээ. Түүнчлэн *Баян-гол*<sup>18</sup> Ульянов, Пензи хоёр мужийн заагаар өнөө хэрнээ урссаар байгааг тэр бээр заасан байна. Барашков Дундад Ижилийн ай саваар байгаа *өндөр, мөрөн* нэрийн оролцоо бүхий газрын биетүүдийн тухай тодорхой өгүүлжээ.

Бессераб хийгээд Кавказын нуруу нь өмнө бидний тэмдэглэснээр эртний үеэс нэгэн хэсэг хүннү болон аваарчууд нутагшиж явсан, хожим нь их Богдын маань Есөн цагаан туг (Есунтүки) мандаж Монголын ихэс дээдэс маань уул, усны олон эздийг нь цэнгүүлж навтаг шавдагийг нь эрхшээж явсан нутаг болой. Энэ нутагт тархсан МГНН-ийн судалгааг Т.А.Гуриев, Н. Jankowski зэрэг цөөнгүй хүн хийж гүйцэтгэсэн байна. Одоо энэ тухай бид Э.А.Гуриев<sup>19</sup>-ын “Топонимы монгольского происхождения в Северной Осетии”<sup>20</sup> зөвхөн нэг өгүүллээр жишээ болгон доор товч өгүүлье.

Т.А.Гуриев Умард Осетиний нутаг дахь монгол язгуур бүхий нэрийг Дундад эртний монголчуудын зан үйл, ахуйн соёлтой холбон тайлбарласан нь өмнөх ижил төрлийн судалгаанаас гойд ялгаатай болжээ. Тухайлбал, тэрбээр сайтар хадгалагдсан дундад эртний дээдсийн оршуулгын газрыг Даргавс (осет. *Дяргъавс*) хэмээн нутгийн уугуул аланууд өдгөө хүртэл нэрлэсээр ирсэн тухай өгүүлжээ. Гуриев монголчуудын албанд орсон нутгийн хүмүүст дундад эртний монголчууд “дарга” цол хайрладаг байсан уламжлалын тухай өгүүлсэн Ререхийн (Roerich G., *Le troupes alanes a L’eroque mongole*, -Ю.Н.Рерих, *Избранные труды*, М., 1967: 245) “Fou-din fut nomme “darga” ou chef d’etat major du flanc droit du corps d’armee de la Garde des Alanes” эш үндэс болгон өнөөгийн монгол хэлний “дарга авс” гэсэн нийлэмж мөн болохыг маргахын аргагүй нотолжээ. Өмнөхтэй төстэй өөр нэгэн баримт бол *Кярдзын* - Карджин и *Бярагъуын*-Барагун оноосон нэрийн түүхэн гаргалаа юм. *Бярагъуын* (оросоор: западный или правый) гэж аланууд Терек голын зүүн эргийн сав газрыг тийнхүү нэрлэдэг байжээ. Түүнээс үүдэн *Кярдзын* нэрийг монголоор “гар зүүн” байж болох таамаглал дэвшүүлж түүнийгээ XIX зууны Оросын нэрт жуулчин, дорнын судлаач Н.Пржевальскийн: “Из обычаев монголов путешественнику резко бросается в глаза их

<sup>17</sup> Хэдхэн жилийн өмнө өчүүхэн миний бие Саратовын их сургуулийн профессоруудтай эрдэм шинжилгээний хамтарсан төсөл хэрэгжүүлж байх үедээ Алтан ордынхоо туурь дээр очиж Саратовын түүхийн музейг үзэж явахдаа Бартольддын дээрх үг дахин дахин санаанд орж “Саратов” хэмээх нэр алтайн өвөг хэлний “шара дов”-оос үүдэлтэй байж болох хувилбар үнэмшилтэй мэт санагдах болсон юм. Тийнхүү бодохын өөр нэг учир нь Саратов хотын бараг төв хэсэгт нэг сайхан улаан ухаа бий. Тэнд би очиж хуруугаараа хөрсийг нь жаахан самардаж үзэхэд доороос нь зос (шороон будаг) гарч ирж байсан нь өмнөх миний санаанд “тос” болсныг нуух юун. Дээрээс нь бас нэг баримт нэмбэл, өнөөгийн Монгол улсын нутаг дэвсгэр дээр бидний МГНН-ийн цахим санд “*Шар дов*” Баянхонгорын Жинст, Завханы Дөрвөлжин, Баян-Өлгийн Цэнгэл, “*Шар довон*” Баян-Өлгийн Баянхус, “*Шар довцог*” Өвөрхангайн Баян-Өндөр суманд тус тус нэгжээд бүртгэлтэй байгааг тэмдэглэх нь эрхбиш хэрэгтэй мэт санагдав.

<sup>18</sup> *Ус, гол, жалга, сайр* гэх мэт монгол хэлний усны тухайт дэвсгэр нэрийн хэрэглээг ОХУ-ын Алтайн хязгаар, баруун, зүүн Шивэр дэх МГНН-ийг сайтар судалсан Э.М.Мурзаев, А.П.Дульзон, О.Т.Молчанова зэрэг олон судлаачийн бүтээлд туссан болохыг зөвхөн тэмдэглэх төдийгөөр цэглэе.

<sup>19</sup> ГУРИЕВ, Тамерлан Александрович (1929), ОХУ-ын К.Л.Хетагуровын нэрэмжит Умард Осетий-Аланий их сургуулийн профессор, ОХУ-ын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн (2002). 1971 онд ЗХУ-ын ШУА-ийн Дорно дахины судлалын хүрээлэн дээр “Отражение монгольских влияний в эпосе и языке алан (осетин)” сэдвээр Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалжээ. Эрдэм шинжилгээний 223 бүтээл туурвисан нэрт судлаач.

<sup>20</sup> Эл өгүүллийг 1974 онд зохиогч “Исследования по восточной филологии” (М., 40-50 с.) эмхтгэлд анх хэвлүүлжээ. Бид эл эхийн монгол хөрвүүлэгийг “Дэлхийд тархсан монгол газар нутгийн нэр”-ийн Гутгаар дэвтэрт (УБ., 2013, 274-280) оруулсан болно.

обыкновение всегда ориентироваться по странам света, никогда не употребляя слов «право» или «лево», словно эти понятия не существуют для номадов. Даже в юрте монгол никогда не скажет, с правой или левой руки, а всегда на восток или на запад от него лежит какая-либо вещь. При этом следует заметить, что лицевую стороною у номадов считается юг, но не север, как у европейцев, так что восток приходится левою, а не правою стороною горизонта" (Пржевальский Н.М., Монголия и страна тангутов, т.1, СПб., 1875: 44-45) тэмдэглэлээс үүдэн монгол нүүдэлчдийн баруун/зүүн-ийг нараар баримжаалсан ойлголт европын, тэр дундаа оросуудын баруун/зүүн гарын ойлголттой таардаггүй гэсэн санааг эш үндэс болгон хөдөлгөөнгүй баталжээ. Гуриев энэхүү бүтээлдээ алан хэлэнд орсон *нар*, *унал* уугуул монгол үгийн язгуурын талаар сонирхолтой баталгаа дэвшүүлсэн байна.

Эцэст нь тэмдэглэхэд харийн улс орнуудад үлдсэн олон мянган монгол нэр Их Монгол улсын түүхэн үед тухай тухайн улс орнуудад болсон монголчуудын тодорхой үйл явдлын үгээр босгосон хөшөө дурсгал болон үлджээ. Тэр бүгдийг сайн үйлт гадаадын судлаачидтай хамтран бидний үеийн монголчууд судалж тогтоох нь манай эрдэмтдийн ариун үүрэг мөн. Түүнчлэн дэлхийд тархсан МГНН нь монгол нүүдэлчдийн түүх-соёлын биет бус соёлын нэгээхэн бүрэлдүүн хэсэг мөнөөс мөн гэсэн санааг илэрхийлэхийг би бээр дээр хичээв.

Ом сайн амгалан болтугай!

## SUMMURY

Mongolian place names are indefeasibly our historic and cultural word-monuments that our Mongolians left through the world in the territories of many other countries during our tracing. Historically, these names were not "imported" by aliens, but they are, doubtlessly, the traces of our ancestors. These names can be classified into two ages namely: immemorial or primitive and medieval.

Historic traces of Mongolian place names at the age of antiquity have not much been recorded in historic sources or have been changed completely because they were not introduced to public or forgotten. On the other hand, the names that were left in the western world, for instance, in European countries at the age of antiquity may probably have been mixed with many names that were left during the Great Mongolian Empire and may have become unobservable. Nevertheless, it can be considered that there are enough evidences of ancient Mongolian names left in the countries of Europe and the south-eastern Asia at the time of antiquity.

For the medieval Mongolian place names, spread through the world, we published three-volume booklet named "Mongolian place names spread through the world" that included the articles, notes and works of many researchers by translating most of them into Mongolian and keeping few of them originally. In the booklet, the researches on approximately 3000 Mongolian place names spread through the world were piled in.

Here, the origin of the most place names was linguistically defined, for instance, from the ancient origin of the words, while a few words were defined as historically and culturally. However, there are also occurrences in which the above aspects have both been considered. Since it is too large to include all the data on the place names, piled in the booklet, we sampled some of them a little comprehensively in this paper.

To conclude, thousands of Mongolian place names, left in foreign countries are certainly our word-monuments that express the events of Mongolians, taken place in the areas at different stages of our history. Therefore, exploring them in cooperation with the sincere foreign researchers is a responsibility of our Mongolian scholars.

Therewith, here I attempted to express a notion that the Mongolian place names spread through the world are an integrant of intangible heritage of nomadic Mongols' history and culture.